

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН БИЕЧИЛСЭН ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ЗАРИМ АСУУДАЛ

SOME PROBLEMS OF DEVELOPING PERSONAL GUARDS IN PRISON INSTITUTIONS



Ч.Батболд

Удирдлагын академийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн удирдлага, стратегийн профессорын багийн ахлах багш, доктор (Ph.D), хошууч

Товч утга: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 267 дугаар зүйлийн 267.2.2 дахь хэсэгт хорих ангийн үндсэн чиг үүргийг “Хоригдлын аюулгүй байдлыг хангах, тэдний дунд хууль ёс, дэг журмыг сахиулах, хоригдол бусад этгээдэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх” гэж заасан байдаг.

Хууль зүй дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-д зааснаар хорих байгууллагын алба хаагчдын тоог нэмэгдүүлэн, хоригдлын зүгээс үйлдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох явдал юм.

Түлхүүр үгс: Жишиг норматив, ажлын ачаалал

Abstract: Section 267.2.2 of Article 267 of the Law on the Execution of Court Decisions states that the main function of the prison is to "ensure the safety of prisoners, maintain law and order among them, and prevent prisoners from harming other persons."

In the "Standard Norms for the Workload of Officers of Court Decision Enforcement Organizations" approved by the joint orders of the Minister of Justice and Internal Affairs, the Minister of Labor and Social Security, and the Minister of Finance No. A/247, A/167, 303 dated September 29, 2017 increasing the number of prison officers and preventing and suppressing crimes and violations committed by prisoners.

Keywords: Benchmarks and workload

Үндсэн хэсэг

Орчин цагийн хорих байгууллага нь 1921 онд байгуулагдсанаас хойш 100 жилийн хугацаанд төрийн эрүүгийн ялын хэрэгжилтийг хангах, хорих ял эдлүүлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтад шууд хамаарах 7 хуулийг хэрэгжүүлж ирсэн уламжлалтай.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль шинэчлэн батлагдсанаас хойш Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 204 дүгээр тогтоолын хавсралтаар “Хорих байгууллага, түүний нутаг дэвсгэрийн байршил, хорих ангийн дэглэм”-ийг шинэчлэн баталж хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлсэн.

Өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд хаалттай хорих анги **5**, нээлттэй хорих анги **7**, нээлттэй, хаалттай хорих анги **5**, сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага **1**, нэгдсэн болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг **2**, эмэгтэйчүүдийн хорих анги **1**, нийт **21** хорих анги, Нийслэлд Цагдан хорих төв **1**, орон нутагт **25** цагдан хорих байртайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Хорих анги, байгууллагуудын багтаамж

Хууль, тогтоомжид хоригдсон этгээдийн “Хорих байрны өрөө нь нэг хүнд 2,5 ба түүнээс дээш хавтгай дөрвөлжин метр талбай ногдохоор байна”¹, хоригдлын “Хорих өрөө нь олон улсын стандартад нийцсэн байна”², “эмнэлгийн өрөө нь 7 м/кв, сүрьеэг эмчлэх өрөө нь 7.5 м/кв талбайтай байна”³ гэсэн зохицуулалттай.

Нэг хүнд ногдох талбайн хэмжээг 3 м/кв талбайгаар тооцон үзвэл:

- Нээлттэй хорих ангиуд **1297**, хаалттай хорих ангиуд **2440**, нийт **3737**
- Цагдан хорих байрууд нийтдээ **1915** хүний багтаамжтай бөгөөд Нийслэл дэх Цагдан хорих төв **685**, орон нутаг дахь цагдан хорих байрууд **23-82** хүний багтаамжтай.

¹Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 24.2. 1999 он

²Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 209.1. 2017 он /ОХУ-д хорих ял эдлүүлэх дэглэм, нөхцөлөөс хамааран 1 хүнд 2.5-5.0 м/кв талбай² ногдохоор хуульчилсан байна/

³Нэгдсэн эмнэлгийн бүтэц, үйл ажиллагааны стандарт MNS 5095:2013. Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2013 оны 63 дугаар тогтоол.

“Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”¹-аар нээлттэй, хаалттай хорих ангиудад 20 хоригдол тутамд 1, хаалттай хорих ангийн тусгай нэгжид 5 хоригдол тутамд 1, нийслэл дэх цагдан хорих төвд 10 хоригдогч тутамд 1, орон нутаг дахь цагдан хорих байруудад 20-50 хоригдогчтой бол 2 хамгаалалтын ажилтан биечилсэн хяналт тавихаар тогтоосон.

Сүүлд 2017 онд шинэчлэгдэн батлагдсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 245 дугаар зүйлийн 245.2 дахь хэсэгт “Хорих ангийн алба хаагч биечилсэн хамгаалалт, жижүүрийн үүргийг дөрвөн ээлжээр гүйцэтгэнэ” гэж заасан мөн жишиг нормативд 20 хоригдол тутамд 1 харуул хамгаалалтын ажилтан хяналт тавьж ажиллах зохицуулалттай боловч одоогоор алба хаагчдын орон тоог жишиг нормативт зааснаар нэмэгдүүлээгүй зарим хорих анги байгууллагууд харуул хамгаалалтыг гурван ээлжээр зохион байгуулан ажиллаж байна.

Техник, технологи өндөр хөгжсөн гадаад улсын практик туршлагыг судлан үзэхэд ХБНГУ, БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонг-Конгийн хорих байгууллагад телехяналтын систем өргөн нэвтэрсэн хэдий ч хүний хүчин зүйл, биечилсэн хяналтыг орхигдуулалгүй 1 харуул хамгаалалтын ажилтан 6-8 хоригдолд биечилсэн хяналт тавин ажилладаг байна.

Монгол Улсад сүүлийн 50 жилд үйлдэгдсэн гэмт хэргийн тоон үзүүлэлтэд судалгаа хийж үзэхэд 1968 онд-3436, 1978 онд-4251, 1988 онд-6614, 1998 онд-22737, 2008 онд-20704, 2018 онд-36620 гэмт хэрэг улсын хэмжээнд бүртгэгдсэн судалгаа байна. Дээрх тоо баримтаас харахад сүүлийн 50 жил гэмт хэрэг 10 дахин өссөн үзүүлэлттэй байна.²

Гэмт хэргийн үзүүлэлтийг 2008-2018 он хүртэл авч үзэхэд 2008-2011 он хүртэл 9,7 хувиар буурч, харин 2011 оноос 50 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Сүүлийн 10 жилийн дунджаас харахад гэмт хэргийн үзүүлэлт жилд 655 хэргээр нэмэгджээ.³


¹Хууль зүй, дотоод хэргийн сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын 2017 оны А/247, А/167, 303 дугаар хамтарсан тушаал.

²АлтангэрэлБ., Мөнх-Эрдэнэ Ч нар. Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ 2003-2018.-Уб., 2019. 30 дахь тал.

³Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөл. Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном. -Уб., 2016. 20 дахь тал.

Монгол Улсад 2007-2010 онд нийт 31393 хүн ял шийтгүүлснээс 23193 хүнд хорих ял оногдуулсан¹ нь нийт ял шийтгүүлэгчдийн 60-аас дээш хувийг хорих ял шийтгүүлэгчид эзэлж байсан байна.

Хоригдлын тоо 5500 орчим байх хугацаанд 1 харуул хамгаалалтын ажилтны биечлэн хяналт тавих хоригдлын тоо дунджаар 70-80 байсан бөгөөд 2015, 2016 онуудад “Өршөөл үзүүлэх тухай хууль”, “Эрүүгийн хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль” хэрэгжсэнээр өршөөл, хуулийн тэгшитгэлд хамрагдан нийт 3495 хоригдол шууд суллагдаж, 2746 хоригдлын эдлэх ялаас дүйцүүлэн хассан тул нийт хоригдлын тоо буурч, ажлын ачаалал жишиг нормативт ойртож байсан боловч хоригдлын тоо жилд дунджаар **400** хоригдлоор нэмэгдэж. Ажлын ачаалал буцаад нэмэгдэх хандлагатай байна.



Цагдан хорих байруудад Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан мөрдөн шалгах ажиллагаанд оролцуулах, өмгөөлөгч болон бусад этгээдтэй уулзах уулзалт зэрэг бүхий л ажиллагаанд харуул хамгаалалтын ажилтан нь хяналт тавьдаг тул хоригдогчийн тооноос шалтгаалахгүйгээр 1 ээлжид 2-оос доошгүй харуул хамгаалалтын ажилтан байх шаардлага практикт бий болдог.

Орон нутагт шинээр баригдсан цагдан хорих байрууд нь зохион байгуулалтын хувьд 2 давхар болсон бөгөөд давхар бүрт хамгаалалтын ажилтан ажиллах шаардлагатай түүнчлэн 4 ээлжээр харуул хамгаалалтын үүрэг гүйцэтгэх тул 20 хүртэлх хоригдогч хүлээн авдаг цагдан хорих

¹Гэмт хэрэгтэй тэмцэх төрийн бодлогын хэрэгжилт. -Уб., 2013. 145 дахь тал.


байруудад 8-аас доошгүй хамгаалалтын ажилтны орон тоотой байх шаардлагатай.

Хорих ял эдлүүлэх явцад үйлдэгдэж буй гэмт явдал буюу олон улсын хэллэгээр “Пенитенциар” гэмт явдал бөгөөд хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад алба хаагч, хоригдол, хоригдогсдын зүгээс холбогдох хууль тогтоомж, хорих ангийн дотоод журам зөрчсөн гэмт хэргүүдийн цогц гэж үзэж болох юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд сүүлийн 10 жилд нийт 79 гэмт хэрэг гарсан ба үүнийг өнгөөр нь авч үзвэл хүний амь нас хохироосон 2 буюу 2.5 хувь, хулгай 3 буюу 3.8 хувь, залилан 1 буюу 1.3 хувь, оргох 31 буюу 39.3 хувь, хүний биед гэмтэл учруулсан 36 буюу 45.4 хувь, танхай 4 буюу 5.1 хувь, хүчин 1 буюу 1.3 хувь, хууль сахиулагчийг эсэргүүцэх 1 буюу 1.3 хувийг тус тус эзэлж байна.

№	Гэмт хэрэг	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	Нийт
1	Хүний амь нас хохироосон	1	1	-	-	-	-	-	-	-	-	2
2	Хулгай	2	1	-	-	-	-	-	-	-	-	3
3	Залилан	1	-	-	-	-	-	-	-	-	-	1
4	Оргох	4	7	4	2	2	3	1	4	-	4	31
5	Хүний биед гэмтэл учруулах	15	10	4	3	1	1	1	-	1	-	36
6	Танхай	4	-	-	-	-	-	-	-	-	-	4
7	Хүчин	-	1	-	-	-	-	-	-	-	-	1
8	Хууль сахиулагчийг эсэргүүцэх	-	-	-	-	-	-	1	-	-	-	1
Нийт		27	20	8	5	3	4	3	4	1	4	79


Хоригдлын зүгээс үйлдсэн гэмт хэргийн судалгаа



Сүүлийн 10 жилд нийт 9526 зөрчил гарсныг өнгөөр нь авч үзвэл гар утас ашигласан 6453 буюу 67.6 хувь, архи уусан 706 буюу 7.5 хувь, албан хаагчийн хууль ёсны шаардлага эсэргүүцсэн, хорих ангийн дотоод журам зөрчсөн 1154 буюу 12.2 хувь, бусдыг дарамталсан, хоригдол хоорондоо маргасан зодолдсон 908 буюу 9.5 хувь, хориотой тоглоом тоглосон, хориотой эд зүйл нэвтрүүлсэн, хадгалсан 305 буюу 3.2 хувийг тус тус эзэлж байна.

Хоригдлын зүгээс үйлдсэн зөрчлийн судалгаа

№	Зөрчил	2013	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	Нийт
1	Гар утас ашигласан	1428	1325	743	302	135	56	18	20	11	10	6453
2	Архи уусан	122	81	26	28	13	9	2	-	2	1	706
3	Албан хаагчийн хууль ёсны шаардлага эсэргүүцсэн, хорих ангийн дотоод журам зөрчсөн	136	170	171	116	95	86	80	89	56	51	1154
4	Бусдыг дарамталсан, хоригдол хоорондоо маргасан зодолдсон	59	77	97	47	43	180	145	151	125	162	908
5	Хориотой тоглоом тоглосон, хориотой эд зүйл нэвтрүүлсэн хадгалсан	38	46	11	21	19	30	24	24	23	42	305
Нийт		1783	1699	1048	514	305	351	269	284	217	266	9526



Практикт 1 харуул хамгаалалтын ажилтан 20-оос дээш хоригдолд биечилсэн хяналт тавих тохиолдолд нүдээр үзэж бүрэн хяналт тавих боломжгүй болж, хоригдлууд урьдчилан төлөвлөсөн гэмт санаа бодлоо хэрэгжүүлэх боломж үүсдэг тул хоригдлын зүгээс үйлдэх гэмт хэрэг, зөрчил ихсэх хандлагатай байна.

Дүгнэлт, санал

Хорих анги, байгууллагын биечилсэн харуул хамгаалалт сул, хүн хүчний хүрэлцээ муугаас Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд сүүлийн 5 жилд нийт 19 гэмт хэрэг гарсан ба үүнээс оргох гэмт хэрэг 12 буюу 63.2 хувийг эзэлж байгаагаас харагдаж байна.

Мөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт 2019 онд Прокурорын байгууллагаас “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчийн ажлын ачааллын жишиг норматив”-г заасны дагуу хорих анги, байгууллагын бүтэц орон тоог зохион байгуулаагүй” гэх үндэслэлээр Булган аймгийн ерөнхий прокурорын 2019 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 07/262 дугаар, Улсын ерөнхий прокурорын туслах прокурорын 2019 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн 6/06 дугаар, Орхон аймгийн ерөнхий прокурорын 2019 оны 06 дугаар 17-ны өдрийн 6/06 дугаар шаардлагыг тус тус ирүүлж байжээ.

Хорих байгууллага нь нийгэмд аюултай гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгэгдсэн хүмүүсийн бөөгнөрөл тул тэдний зүгээс гэмт хэрэг үйлдэх магадлал өндөр байдаг. Иймээс нэн тэргүүнд дараах 3 орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай байна. Үүнд:

1. Дүрс, бичлэгийн хяналтын ажилтны орон тоо батлагдаагүй хорих анги, байгууллагуудад хамгаалалтын ажилтан, холбоочин зарим тохиолдолд ерөнхий жижүүрүүд уг үүргийг хавсран гүйцэтгэж байгаа нь хоригдол,

хоригдогчид тавих хяналт суларч гэмт хэрэг, зөрчил гарч болзошгүй байх тул дүрс бичлэгийн хяналтын ажилтныг томилуулах;

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 232.2 дахь хэсэгт *“Хоригдлын биед хийх үзлэг нэгжлэгийг хоригдолтой ижил хүйсийн алба хаагч гүйцэтгэнэ”*, Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 33.5 дахь хэсэг *“Хоригдсон этгээдийн биед хийх үзлэгийг түүнтэй ижил хүйсийн хамгаалалтын ажилтан хийх бөгөөд үзлэгээр илэрсэн гэмтэл, шарх сорви болон биеийн жин, өндөр, онцлог, содон тэмдгийг бүртгэж, хувийн хэрэгт нь бүрэн тэмдэглэнэ”*, Шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа, үзлэг, нэгжлэгийн стандартын 6.1 дэх хэсэгт *“...ялтан, хоригдогч бусад этгээдийн бие, хувцас, эд зүйл, тээврийн хэрэгсэл, хорих байр, өрөө, үйлдвэрлэлийн болон бусад зориулалтын барилга, байгууламжид үзлэг, нэгжлэг хийнэ”* гэж тус тус заасны дагуу цагдан хоригдож буй эмэгтэй хоригдогч болон хоригдол хоригдогчид эргэлтээр ирж буй иргэдийн бие, эд зүйлд тэдэнтэй ижил хүйсийн алба хаагчаар үзлэг хийлгэх шаардлага тулгардаг тул эмэгтэй хамгаалалтын ажилтны орон тоог нэмэгдүүлэх;

3. Батлагдсан орон тоогоор хамгаалалтын ажилтны тоо их харагдаж байгаа боловч ШШГБ-ын хэмжээнд 24 цагийн жижүүрлэлтэд **139** харуул хамгаалалтын ажилтан ажиллаж байна. Бусад хамгаалалтын ажилтан нь хорих ангийн гадна хамгаалалт, нэвтрэх хэсэг, хуяглан хүргэх ажиллагаа, үйлдвэрлэлд үүрэг гүйцэтгэдэг тул хамгаалалтын ажилтны орон тоог нэмэгдүүлэх зэрэг болно.